

Гончигийн Батболд[✉], Батмөнхийн Цогтбаатар¹, Гөөнийгийн Лхүндэв¹,
Гэлэгдоржийн Эрэгзэн¹, Цэрэнхандын Буянхишиг¹

¹Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Монголын эзэнт гүрний өмнөх үеийн булш, оршуулгын судалгаа

Хураангуй. Монголын Эзэнт гүрнээс өмнөх үеийн монголчуудтай холбогдох археологийн дурсгал бага судлагдсан бөгөөд одоогоор зарим нэг санамсаргүй байдлаар малтсан Уйгурын төгсгөл, Хятаны үеийн монголчуудын оршуулгын дурсгал байна. Бидний судалгааны баг 2021, 2024 онд Хэнтий аймгийн Дадал сумын Эрээн толгойн оршуулгын дурсгалд малтлага судалгаа хийсэн бөгөөд энэ нь Хятаны үеийн монголчуудын булш юм. Эрээн толгойн оршуулгын газрын оршуулгын зан үйлийн онцлог нь талийгаачийг голдуу зүүн гурван зүгт толгойг нь хандуулах бөгөөд баруун хажуугаар нь хэвтүүлээд, хөлийн өвдгийг нь бага зэрэг нугалан оршоож, үүнд хойд насны идээ болгож заавал богийн дал, хутга дагалдуулах онцлогтой.

Түлхүүр үг. Өвөг Монгол, оршуулгын зан үйл, булш, дал, хутга

Batbold Gonchig[✉], Tsogtbaatar Batmunkh¹, Lkhundev Guunii¹,
Eregzen Gelegdorj¹, Buyankhishig Tserenkhand¹

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-I
Peace Avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Research on tombs and burials from the pre-Mongol Empire period

Abstract. Archaeological sites dating to the pre-Mongol Empire period are extremely rare. Burial sites associated with the Mongols from the end of the Uyghur period are particularly scarce, with only a few graves having been excavated accidentally. The Ereen Tolgoi burial site, located in Dadal soum, Khentii aimag, was excavated by our research team in 2021 and 2024, reveals a Mongol tomb from the Khitan period. The funeral rituals at the Ereen Tolgoi cemetery are characterized by the deceased being laid on their right side, with the head oriented towards the northeast, east, or southeast, and the legs slightly bent at the knees. These burials are accompanied by ritual elements associated with beliefs of the afterlife, including a small cattle palm bone and a knife.

Keywords. Mongol ancestor/ protomongolia, funeral rituals, grave, palm, knife

Монголын эзэнт гүрний өмнөх үеийн монголчуудын түүх, археологийн баримт хэрэглэгдэхүүн харьцангуй дутмаг байдаг. Харин Монголын үед хамаарах 800 гаруй булш оршуулгыг одоогоор малтан судлаад байгаа бөгөөд магадгүй эдгээр булшнуудад хамааруулж тодорхой хэмжээгээр малтан судалсан байх боломжтой. Учир нь, малтсан булш бүхэнд он цаг тогтоох C^{14} нүүрстөрөгчийн шинжилгээ хийх боломжгүй юм.

Монголын эзэнт гүрэн байгуулагдах түүхэн нөхцөл хэрхэн бүрдсэн талаарх судалгаа хомс байдаг. “Монголын нууц товчоон”-д XII зууны үеийн зарим түүхэн үйл явдлуудыг тэмдэглэн үлдээсэн нь бий. Харин Монголын эзэнт гүрний булш оршуулгад өмнөх үеийн улбаа туссан байх ёстой учир өөр хоорондоо адил төстэй, ялгаа нь тэр бүр мэдэгдэхгүй байж магадгүй.

Түрүү дундад зууны монгол булшийг анх Оросын археологичид Байгал нуур, Сибирь, Алс Дорнодод малтан судалсан билээ. Байгал нуурын орчимд илэрч судлагдсан булшинд тулгуурлан Монголын эзэнт гүрний археологийн соёл бий болоход “ирмэл” бүрдлүүд чухал үүрэгтэй оролцсон гэж үздэг судлаачдын дийлэнх нь монголчуудын “уугуул” нутаг гэгдэх Зүүн Өвөр Байгал, Манжуур хавиас монголчуудын өвөг дээдэс Дорнод Монголд нүүн ирсэн тухай таамаг дэвшүүлдэг. Тухайлбал, Эргүнэ-кунгийн домогтой холбон тайлбарлаж, Аргун гол, Гурван гол (Онон, Хэрлэн, Туул) орчим нутаг бол монгол угсаатан бүрэлдэн бий болсон чухал төв хэмээн үздэг (Okladnikov, 1976). Судлаач, археологич С.Өлзийбаяр Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгч (Чингис)-ийн хэрмээс малтан судалсан Бурхотуйн соёлтой холбоотой бүлэг булш, археологич Ц.Төрбат нарын малтан судалсан Дорнод аймгийн Гурванзагал сумын Хөх нуурт малтсан 2-р булш зэрэг нь ОХУ-ын нутагт малтан судалсан Бурхотуйн соёлд (НТ III-XI) хамаарч байна. Дээрх судлаачид эдгээр хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнийг харьцуулан судалж, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийг орос, монгол хэлээр хэвлүүлсэн байна. Чингэхдээ, Түрүү Монголын соёл хэмээн нэрлэсэн тус эртний булш нь монголын үед холбогдох бусад дурсгалаас бүтэц зохион байгуулалт, оршуулгын зан үйл, зүг чиг, хамаарах он цаг зэргээр ойролцоох хил залгаа дурсгалаас ялгаатай болохыг тодорхойлж, тусдаа бие даасан соёл хэмээн үзжээ.

Бид энэхүү өгүүлэлд Монголын зүүн бүсийн нэгэн дурсгалын жишээн дээр зарим нэг тайлбар хийж болохоор байна.

Хэнтий аймгийн Дадал сумын Онон багийн төвөөс хойш 2 км-т Эрээн толгой хэмээх дурсгалт газар байрлана. Уг толгойн баруун талд Өндөр хайрхан хэмээх сондгой өндөр уул харагдах бөгөөд түүний баруун талаар нь Сэрүүн булаг урсдаг.

Тэрхүү булгийн урд талд Шар Тогоот хэмээх уул бий.

Эрээн толгойд дэвсгэр зураг үйлдэхэд нийт 68 булштай болох нь тогтоогдсон. Энэхүү оршуулгын газар Эрээн толгойн урд энгэр уруу буусан хоёр богино хошуу мэт хамарын дунд урагш харсан энгэрт нь байрлана. Малтлага судалгааны үеэр булшны дарааснаас мал амьтны яс илэрч байсан нь сонирхолтой байна. Эдгээр олон тооны яс, булшны тахилгатай холбоотой юу? эсвэл толгойн нөмөр бараадаж хэсэг хугацаанд байсан өвөлжөөний нөлөөгөөр үлдсэн үү? гэдэг нь эргэлзээтэй. Гэхдээ булшны дараас чулуунд гүн дарагдсан байгаа нь оршуулах үеийн тахил байж ч болохоор дүр төрх харагдаж байна.

Тухайн оршуулгын газрын хамгийн том булш нь 7 м голчтой, жижиг булшнууд 1 м орчим голчтой байна. Булшны хадгалалт маш муу, дийлэнх булш тоногдсон шинжтэй бөгөөд томхон булшнуудын дараасын төв хэсэгт тонож чулуудыг гарган эргэн тойрон шидсэн нь хүннү булшийг санагдуулахуйц хэлбэртэй болжээ. Бид 2021 онд оршуулгын газрын баруун хойд буланд 2, зүүн хойд буланд 1, төв дунд 1, нийт 4 дундаж булш сонгож малтсан (Batbold et al. 2021). Дэвсгэр зурагт өгсөн дугаар дагуу 2021 онд 4, 20, 24, 35-р булшийг малтан судалсан бол 2024 онд 1, 3, 56, 62, 66, 53 гэсэн 6 булш буюу нийт 10 булш малтлага судалгаанд хамрагдсан юм. Эрээн толгойн баруун талын хамрын үзүүрээс залган булшнуудын урдуур тойрч эмжээд зүүн талын хамар луу өгссөн зэл чулуу мөн ажиглагдаж байна. Энэ нь тус оршуулгын газрын хүрээ хязгаарыг нарийвчлан тогтоож өгсөн зурвас бололтой. Мөн тус толгойн оройд ойролцоох дэлийн урд хэсэгт арай хожуу үеийн 5-6 монгол булш байна. Үүнээс харахад, нэгэн ууланд хоёр ойр цаг үеийн булш байршлын хувьд багахан ялгаатай байгаа нь сонирхолтой юм. Бид нийт 10 булш малтан судлаад байгаа бөгөөд эдгээрээс 4 булшийг төлөөлөл болгон авч үзнэ. Тэдгээр нь 24, 56, 62, 66-р булш юм. 24-р булш насанд хүрсэн эрэгтэй хүний, 56-р булш хүүхдийн, 62-р булш хос оршуулгатай, 66-р булш нярайн хамт оршуулсан эмэгтэй хүний булш байв (Batbold et al. 2024). Эдгээр дөрвөн булш энэ үеийн оршуулгын зан үйлийг бүрэн төлөөлж байна хэмээн үзлээ.


Булш-24. Тус булш нь оршуулгын газрын баруун хойд захын булш юм. Дараасны байдлаас харахад хөндөгдсөн нь илэрхий харагдах ба чулууг газрын уруу буюу урд талд нь овоолсон шинжтэй байна. Бид 5 x 5 м талбайд булшны дараасыг хамруулан 10 см зузаантай зохиомол үе үүсгэн дараасыг цэвэрлэв. Эхний үеийн цэвэрлэгээний дараа булшны нүх чухам хаана байгаа болон тонуулчин хаагуур орсон нь илэрхий харагдаж байв. Дараасыг цэвэрлэх явцад бод, богийн яс эмх замбараагүй илэрч олдож байсан бөгөөд араатан

амьтны эрүүний яс илрэв. Тонуулчны нүхний чиглэлд тааруулан зүсэлтийн зураг хийх тигийг зүүн хойд зүгт тааруулан татав. Дараасыг авахад зарим чулуу гүнзгий суусан байснаас шалтгаалан 30 см зузаантайгаар булшны нүхийг тааруулан 2х3 м хэмжээтэйгээр талбайг жижгэрүүлэн малтав. Энэ үеийн малтлагын дараа оршуулгын нүхний чиглэл тодорхой болсон ба зүүн хойш 37°-т чиглэнэ. Булшны нүхний толгой хэсгээр 110 см, хөл талаараа 70 см өргөн, 3 м орчим урт хэмжээтэй толбо байна. Дараагийн үеийн малтлагыг оршуулгын нүхэнд нь цааш үргэлжлүүлэхээр болов.


Оршуулгын нүхэнд малтлагын зохиомол үеийг 10 см-тэй доош явуулахад чигжээс чулуу олон үе байв. Чулууг цэвэрлэх явцад ясан бороотой дуут зэв, түүний хажуугаас хүний сүүжний яс илрэв. Хүний зүүн гуяны орчим нумын ясан наалтын хэсэг илрэв. Энэ үеийн малтлага дууссаны дараа хүний яс, чигжээсийг баримтжуулан авав. Дараагийн үеийн малтлага эхлэхэд хүний толгой яс илэрснээр энэ үеэс оршуулга илрэх нь тодорхой болсон юм. Толгойн ясны түвшинд булшны нүхний ханыг дагуулан хавтгай голдуу чулуу хавиргалан босгосон байв. Энэхүү чулууны байрлалаас харахад булшны нүх давчуу нарийн бололтой. Хүний толгойн баруун дээд талаас ваар илэрч эхэлсэн бөгөөд саарал өнгөтэй хятаны дусал хээтэй ваар анхны байрлалдаа байгаа бололтой, хөрсний даралтаас үүдэж цуурсан ажиглагдана. Хүнээ дээш тэнэгэр

байдлаар оршуулсан боловч хүний нүүр зүүн тийш харсан байдалтай зүүн гарыг тохойгоор нь нугалан шанаа тулсан мэт байрлалтай байгаа бол баруун гарыг тохойгоор нь бага зэрэг нугалж бүсэлхий дээр нь тавьжээ. Тохойн нугаларсан нугалааны дотор баруун суганд богийн далны ясыг толгойг нь хүний толгойн чиглэлтэй залааг нь дээш харуулж тавьсан байна. Далны ясны залаан орчимд төмөр хутгыг далтай зэрэгцүүлэн тавьсан байна. Булшийг тонохдоо мах яс салсан үед хүний бүсэлхий орчимд орж ямар нэгэн зүйл татан авснаас болж хүний сүүжний яс хөндөгдөж гарсан бололтой байна. Бусад яс бараг анатомийн байрлалаараа байна. Хүний баруун гуяныг дагуулан хоромсого тавьсан байсан бололтой ясан чимгүүд илрэв. Ясан чимгийн хадгалалт маш муу бөгөөд хоромсогойн үйсэн их бие байхгүй болсон ба жижиг үйсний үйрмэг гарсан юм. Хоромсогойн ясан чимэглэл дээр давхар дугуй хээг өрөмдөж гаргасан бөгөөд тэдний зарим нь гүн өрөмдсөнөөс нэвт цоорсон байдалтай байна. Хоромсого дотор байсан бололтой хийвэр (Bazarsuren, 2009) зэв нэг ширхэг илрэв.

Хүний хөлийн тавхай ясны орчимд хэт, цахиур чулуу илрэв. Оршуулгын хэсгийг бүрэн баримтжуулсны дараа олдвор хүний ясыг авч оршуулгын нүхийг бүрэн шалгах явцад ямар нэгэн зүйл ахиж илрээгүй тул малтлагыг зогсоов. Малтлагын гүн 160 см болов.



Зураг 1. 24-р булшны оршуулгын хэсэг, олдворууд.
1. Ваар, 2. Богийн дал, 3. Хутга, 4. Хоромсогойн ясан чимэг, 5 Нумын ясан наалт, 6, 7. Зэв, 8. Хэт цахиур.




Зураг 2. 24-р булшны дараас


Олдворын тодорхойлолт. Төмөр хутга: Нийт урт 15 см, ирний хэсэг нь 11.5 см бөгөөд 4.5 см нь ишний зуулга байна. Хутганы өндөр нь 1.7 см бол зузаан нь мөр талаараа 0.3 см байна. Ишний зуулга хэсэгт модны наалдсан хэсэгтэй бөгөөд модон бариултай байсныг илтгэж байна. **Хэт:** Урт нь 7 см, өргөн нь 2.8 см, зузаан нь 0.7 см байна. Хуягийн ялтас мэт гонзгой зууван харагдана. Цахиур нь хасын төрлийн чулуу ба 2.5 см өндөр, өргөн 1.5 см байна. **Вааран сав:** Савны өндөр нь 22 см байна. 4 см өндөр хоолойтой хятаны үеийн дусал хээгээр 9 үе хээлсэн бөгөөд үе бүр 2-3 эгнээгээр хээлсэн байна. Ваарын амсар нь 8 см диаметртэй, зузаан нь 0.5 см байна. Ваарын ёроолыг эргэх хүрднээс утсаар зүсэн салгасан ул мөр тодорхой байна. **Бороотой дуут зэв:** Гурван жигүүртэй бороотой зэв. Зэвийн урт 3 см, бороо нь гурван нүхтэй урт нь 4 см байна. Энэ төрлийн зэв дүгрэг бороот зэв хэмээдэг ажээ. **Хийвэр зэв:** Зэвийн нийт урт 10.5 см бол сурвалж нь 4.5 см, мөс нь 6 см байна. **Нумын ясан наалт:** Наалтын урт 16 см, өргөн нь 1.5 см, зузаан нь 0.4 см. Уг наалт нь нумын хөдөлгөөн багатай бариулын наалтын хэсэг байна. **Хоромсогын ясан чимэг:** Ясан чимэг нь хугархай бөгөөд нөхөн сэргээвэл 8 х 12 см хэмжээтэй зузаан нь 0.1 см нарийн зассан ясан наалт байна. Дээр нь давхар

онги хээгээр чимэглэсэн байна. Том дугуй 0.5 см голчтой бол жижиг дугуй 0.1 см орчим голчтой байна. Мөн эдгээр наалтын амыг дарж байсан бололтой нарийн ясан наалт байна. Түүний урт нь 10.5 см өргөн нь 0.9 см бөгөөд түүнийг тогтоож байсан төмөр хадаас одоо наалтын дээр байна. **Хоромсогын ясан гох.** Ховдын зүүхэд хэрэглэж байсан ясан гох хоёр ширхэг илэрсэн юм. 1-р гох урт нь 10.2 см урт бөгөөд бага зэргийн дотор тал руугаа ээтгэр гох мэт хэлбэртэй. Зузаан нь 0.5 см бөгөөд ховдын ясан наалтын хээтэй адил давхар онги хээтэй. 2-р гох урт нь 16.8 см урт зузаан нь 0.5 см дээрхтэй адил чимэглэлтэй. Дунд хэрдээ мөн адил гох маягийн ухсан бөгөөд энэ хэсэг зүүхэд чухал үүрэгтэй бололтой ихээр элэгдсэн байна. **Далны яс.** Богийн баруун далны яс байна.

56-р булш. Энэхүү оршуулгын газрын хамгийн жижиг дараастай булш гэж үзэж болно. Бид тус булшийг хүүхдийн булш байж болно хэмээн сонгон малтсан юм. Малтлагыг 3 х 3 м талбайд дараасыг хамруулан эхэлж, 1-р үеийг цэвэрлэв. Үүний дараа дараас зүүн тийш чиглэсэн зууван дугуй ба огт хөндөгдөөгүй гэдэг нь илэрхий харагдаж байв. Дараас чулууг баримтжуулахад жижиг чулуу голдуу ашигласан байсан боловч дараасыг



Зураг-3. 24-р булшны олдворын гар зураг



Зураг 4. Були-56. 1. Дэр чулуу, Ваар, 3. Шавар эдлэл, 4. Богийн дал, 5. Хутга




Зураг 5. Були-56. Дараас, зүсэлт

авсны дараа оршуулгын нүхийг нүхний өргөнтэй том чулуугаар даран тагласан байв. Нүхний амыг хөндлөн том чулуугаар тэгнэн дарсан нь оршуулгын хэсгийг дотогш цөмрөхөөс хамгаалсан бололтой. Бид чигжээс чулууг авсны дараа авсны мод илэрч эхэлсэн бөгөөд хадгалалт сайн байлаа. Толгой болон хөл хэсэгт зузаан мод илэрч байна. Авсан дотор толгой талд нэгэн ваар дагалдуулсан нь илэрч эхлэв. Булшийг бүтэн цэвэрлэхэд авс нь 100 x 35 см харьцаатай байна. Авсны хойд хана чигжээс чулуунд хавчигдсан бололтой дунд талаараа 30 см өргөн байна. Булшийг бүтэн цэвэрлэхэд хүний толгойн яс дарагдаж бяцарсан байна. Дутуу шатаасан вааран эдлэл илэрч байсан бөгөөд чухам яг юуг нь тодорхойлж чадсангүй. Магадгүй хүүхдийн тоглоом эсвэл намхан ирмэгтэй хавтгай таваг байсан бололтой. Ваарыг толгойн баруун хажуу тушаа үл ялиг дээр тавьсан бөгөөд толгойн доор жижиг чулууг дэр болгосон бололтой байна. Толгойн яс, мэрэгчийн үйл ажиллагаанаас үүдсэн үү доош өнхөрч цээжний тушаа ирсэн байна. Ваарын зүүн тушаа хавирганы яс анхны байрлалд буй нь ингэж үзэхэд хүргэж байна. Талийгаачийн ташаан дээр богийн дал, хутга байрлуулсан байна. Далны яс нь хүүхдийн булш гэхэд бусад булшнаас хамаагүй том бүдүүн богийн яс байна. Чигжээс чулуунд дарагдсанаас болсон уу ваарын ёроол хэсэг бяцарснаас бусдаар бараг бүтэн бөгөөд амсрыг зан үйлтэй холбоотойгоор багахан эмтэлсэн байв. Хүүхдийн ясны хадгалалт муу байна. Далны толгой, хутганы үзүүрийг хөл тал руу чиглүүлсэн байна. Хүний ясыг авч байх үед шилбэ орчмоос дан цахиур чулуу илрэв. Малтлагын гүн 145 см байна.

Авсны өндөр 23 см, зузаан нь хамгийн нимгэн талдаа 1.5 см байна. Хөл хэсэгт өргөн 30 см, толгой талдаа 45 см өргөн байжээ.

Олдворын тодорхойлолт. Дусал хээтэй ваар: Ваарын өндөр нь 21 см, амсар гадна талаараа 8.5 см голчтой бол дотор тал нь 7 см байна. Бөөрний талаас доош ёроол хүртэл дусал хээтэй бөгөөд хээ хамарсан өндөр 8 см нийт 7 үе хээлжээ. Амсрын хоёр хэсэг газар сэтлэн тавьжээ. Цахиур чулуу: Хасын төрлийн улаан чулуу 2.5 x 2.5 см байна. Төмөр хутга: Нийт урт нь 13 см байна. Ирний урт нь 9 см. Ишний зуулга 4 см, мөр 0.5 см зузаан байна. Дал: Богийн зүүн дал байв.

62-р булш. Тус оршуулгын газрын 61, 62-р булш бусдаас харьцангуй том хэмжээтэй бөгөөд 62-р булшны дараасын хэлбэр арай тод учир сонгож малтлаа. 8 x 8 м хэмжээтэй талбай татан малтлагыг эхлүүлэв. Уг булш гадна талаасаа хүннү булшийг санагдуулахуйц адил дугуй цагариган дараастай, гол хэсэгтээ хонхор юм. Энд буй том булшуудыг тоносон бөгөөд дараасын голын чулууг нь гадагш шидсэнээс дараас мөн тэгж харагдах талтай. Бид дараасыг авч байхад бодын богтос бяцарсан байдалтай илрэв. Дараас дундаас хүний дунд чөмгөний толгой, адууны толгойн дагз, мөчдийн яс гэх мэт зүйлс илэрч байна. Дараасыг бүтэн хуулсны дараа хойноос урагш 220 см, зүүнээс баруун тийш 260 см тэгш өнцөгт чигжээс бүхий оршуулгын том нүх илэрч байна. Чигжээсний баруун хойд талд чулуу цөөн бөгөөд нүхний тэгш хэм алдагдсан бөгөөд үүгээр тонуул орсон бололтой. Оршуулгын




Зураг 6. 1. Ваар, 2. Шавар эдлэл, 3. Цахиур, 4. Хутга


220 x 260 см нүхийг зургаан талт харандаа чулуугаар эгнүүлэн зулж тагласан байжээ. Тонуулын нүхнээс бусад хэсэгт 1-2 үе давхарлан чигжсэн байна. Оршуулгын нүхний чиглэлд харандаа чулууг бага зэрэг зайтайгаар зэрэгцүүлэн тавиад дараагийн үед тэдний завсарын өнцгөөр амыг нь дарах маягаар өрж хийсэн байжээ. Эдгээр 3-4 үе өрсөн чигжээс чулууг авсны дараа 190 см гүнээс урд талдаа шахсан авсны мод бололтой зүйл илэрлээ. Энэ мод гарахын өмнө дээд талаас гурван ширхэг харвуулын зэв ундуй сундуй илрэв. Оршуулгын нүхний хойд талаас тонуулчид чигжээс чулууг хөндөхгүйгээр шинээр ухан ороод оршуулгын хэсгээс 50 см дээр ирээд доош ухалгүй оршуулга руу хаван орсон байна. Ингэхдээ өөрсдийн зогссон хэсэгт нүх ухсан багаж болох царил? (жад) орхисон байв. Царилын үзүүрийг хөл тал руу чиглүүлэн орхижээ. Магадгүй энэ түвшинд ирээд царилын модон иш хугарсан учир тэнд нь орхих шалтгаан болсон бололтой. Булш бол бүрэн тоногдсон чигжээс дундаас 1 см зузаан нарс мод бололтой авсны мод ихээр гарч байв. Мөн тонуулчдын нүхнээс хүний яс ихээр гарч байв. Булш эрт тоногдсон учир авс ихээр эвдэрсэн бололтой бөгөөд ухмал модон авс гэдгийг арай гэж таньж байна. Хүний өвдөгний багцаа байрлалаас 3-р булшнаас илэрсэн сувстай адил харандаа (цилиндр) сувс 1 ш гарав. Зүүн урд булангаас хормого байсан бололтой 10 x 10 см хавтгай үйс илрэв мөн түүний орчмоос 2 ш цилиндр сувс гарав, урт нь 1.6 x 1.1 см байна. Хүний ясны дунд чөмөг толгой орчим татагдан ирсэн байна. Эндээс хүзүүний зүүлт, алтан ээмэг гэх зүйлс илрэв. Мөн цагаан чулуу мөнгөнд суулгасан гоёл илрэв. Жижиг усны дусал мэт хэлбэртэй ногоон сувс 1 ш, мөн түүний хажуугаас мөнгөөр жаазалсан хар чулуун? (үйс мэт зөөлөн) сувс 1 ш илрэв. Авсны модны

урт нь тодорхойгүй ба одоо мэдэгдэж буй үлдсэн урт нь 55 см, өргөн нь 22 см, зузаан нь 0.5-1 см ба авсны хажуу хана л үлдсэн байна. Булшны гүн 240 см хөл талд 290 см болоод байгалийн хөрс гарч дуусав. Тонуулчдын гараар ваар гарсан бололтой. Ваарын хагархай 2 ш илэрсэн бөгөөд хоёулаа хоёр өөр сав болох нь илэрхий боловч бусад хэсэг нь илэрсэнгүй. Шороог шигших явцад мөнгөн жаазаар бөгжилсөн хар сувс илрэв гэвч чулуу биш бололтой бөгөөд зүүлтийн унжлага бололтой байна. Эндээс гарч буй хүний яснаас харахад уг булш хоёр хүний оршуулга болох нь тодорхой болов. Тонуулчид хоёр хүний ясыг бүрэн сүйтгэсэн бөгөөд мах яс яг салж байх үед тоносон бололтой. Зүүн талын булшны эзэн эмэгтэй хүн бөгөөд ухмал модон авсанд, баруун талын дагуул хүн авсанд байсан гэх ул мөр илэрсэнгүй. Тонуулчид дагуул хүний бүсэлхий орчмоор нүх ухан булшинд 2 м гүн орчим дөхөөд чигжээс чулууны хажуу талаас багахан эвдэж шурган орсон байна. Тонуулчдыг тонох үед оршуулгын хэсэг бараг хөндий байсан бололтой байна. Булшны эзэн эмэгтэйн шарилыг тонохдоо авсыг хажуугаас нь эвдэж булшны дунд ясыг татаж овоолсон байна. Дагуул хүний яс тонуулчдын нүхний дагуу татагдан бараг бүрэн тарсан байдалтай байв. Булшны эзэн 55-60 орчим насны эмэгтэй байсан бол дагуул хүн нь 12 орчим настай хүүхэд хэмээн гарсан бөгөөд эрэгтэй хүүхэд бололтой. Дагалдуулсан зүйл, эд өлөг зэргээс харахад эмэгтэйн хүүхэд гэхээсээ илүүтэй хойд насанд нь хань бараа болгосон хөтөч, боол байсан байж болох талтай байна. Учир нь хүүхдийн шарил австай байсан гэх ул мөр юу ч үлдсэнгүй. Мөн дагалдуулсан дал махан хүнс, хутга оршуулсан хүн тус бүрд бус нэг илэрсэн нь ингэж үзэх шалтгаан болж байна. Мөн дагалдуулсан нумын ясан наалт нь жижиг алангир нум байгаа зэрэгтэй холбон тайлбарлаж болох юм.

Олдворын тодорхойлолт. Сувс-1: Ногоон өнгөтэй ногоолин чулуун сувс. Дусал мэт хэлбэртэй дотор тал нь тод ногоон судалтай байгалийн 4 ширхэг судал байна. Энэ чулуун сувсны өндөр нь 1.2 см, 0.5 голчтой зүүлтийн унжлага байж магадгүй байна. **Сувс-2:** Хар зөөлөн чулууг мөнгөлсөн сувс. Урт нь 2.2 см, зузаан нь 0.4 см байна гадна талаар нь дөрвөн дэлбээ мэтээр аманд нь залгуулж 8-ын тоо мэтээр торлон жаазалж мөнгөлсөн байна. Сүвлэх нүх 0.2 см байна. Энэ чулуу их зөөлөн учир мөнгийг жаазлахдаа дотогш суулгаж өгсөн байна. **Чулуун зүүлт унжлага:** Мөнгөнд суулгасан цагаан чулуун эдлэл. Өндөр нь 3.5 см. Уг чулууг суулгасан мөнгөн дээр навчны хээ мэт зураас тавьсан байна. Үүнээс харахад дэлгэрч буй бадма цэцэг мэтээр харагдаж байна. **Алтан ээмэг:** Тус ээмэг нь “G” хэлбэрийн ээмэг юм. Нийт урт нь 2.8 см, өргөн нь 1.8 см бөгөөд урагш товойн гарсан тээг чимэг



Зураг 7. Булш-62. 1. Алтан ээмэг, 2. Мөнгөн сувс, 3, 4, 5, 14. Харандаа сувс, 13. Цагаан чулуун зүүлт, 6. Зэв, 8. Богийн дал, 9. Хутга, 10. Царил, 11, 12. Ваарын амсар, 15. Нумын ясан гичир, 16. Үйсэн эд. 17. Цахиур.



Зураг-8 Булш-62. Дараас, зүсэлт.

нь 0.5 см орчим. Ерөнхий гархины цувимал голч нь 0.3 см. Ээмэгний чихэнд сүвлэх үзүүрт нэгэн нүх гаргаж өгсөн нь чихэнд сүвлээд хооронд нь утсаар холбодог байжээ. Сувс-3: Эдгээр сувс нь хоёр талаас нь нарийн зүйлээр өрөмдөн нэвт сүвлэх нүх гаргасан ба заримд нь нэвт гэрэлтэх байдлаас ийм байдалтай хийдэг бололтой. Эдгээрийг хэлхэн зүүхэд хоорондоо харшдаг бололтой сувсны үзүүр хэсгүүд нь эмтэрсэн байна. Нийт 6 ширхэг илэрсэн тул ийнхүү дугаарлав.

№1: Урт нь 3.3 см, багахан хэсэг нь хугарсан байна. Голч нь 0.8 см өргөн, нимгэн мөнгөөр бөгжилсөн байна. Сүвлэх нүх сувсны төвийг голлоогүй байна.

№2: Урт нь 6 см, голч нь 0.7 см байна. Сүвлэх нүх 0.15 см байна.

№3: Урт нь 5 см, 0.8 см голчтой. Сүвлэх нүх нь 0.1 см байна.

№4: Урт нь 4 см, 0.7 см голчтой. Сүвлэх нүх нь 0.1 см байна.


№5: Урт нь 4 см, 0.5 см голчтой. Сүвлэх нүх нь 0.1 см байна.

№6: Урт нь 3.4 см, 0.7 см голчтой. Сүвлэх нүх нь 0.12 см байна.


Цахиур чулуу-1: 2.2 x 2.2 см талбайтай цахиур чулуу. Цахиур чулуу-2. Хасын төрлийн улаан чулуу 2x3.2 см хэмжээтэй. Нумын гичрийн ясан суулгац: Урт нь 4.2 см өргөн нь 0.7 см. Нумын чихийг голоор нь цуулж хөвч татах хэсэгт нэмэлтээр голд нь суулгаж өгдөг гичир байна. Төмөр зэв-1: Зэвийн нийт урт нь 8 см, сурвалж нь 3.8 см. Жалан хошуу зэвтэй тун төстэй байна. Төмөр зэв-2: Хаймуур (Хийвэр) зэв, үзүүрийн хэсэг таллан хугарсан нийт

урт нь 7.5 см, сурвалжийн урт нь 3.5 см байна. Төмөр зэв-3: Зэвийн нийт урт нь 7.8 см, сурвалжийн урт нь 4.2 см. Сэрвээт сумын нэг төрөл байна. Төмөр зэв-4: Зэвийн нийт урт нь 7 см, сурвалжийн урт нь 3 см байна. Жалан хошуу сум хэмээх төрөлд багтаж болохоор байна. Царил. Үзүүр нь 1.4 см. Зузаан нь үзүүр хэсэгтээ 1 см байна. Хойд талдаа модон иш шургуулах задгай оньтой. Онги урт нь 8.2 см онгины зай 1.2 см. Царилын урт нь 22.3 см байна. Онгины голч нь 4.3 см байна. Онги гаргасан хэсгийн төмрийн зузаан 0.6-0.5 см байна. Энэхүү царил нь тонуулчдын нүхний ёроолоос илэрсэн бөгөөд зарим бүтээлд жад хэмээн үзсэн байна. Магадгүй жад байж болохоор юм. Ваарын хагархай-1. Өргөн амсартай ваарын амсрын хэсэг голч нь 14 см. Амсрын 15% үлдэн хоцорсон байна. Шатаалт сайтай саарал Хятаны үеийн ваар. Ваарын хагархай-2. Дусал хээтэй ваарын бөөрний хэсгийн хагархай, ваарын бүсэлхий 26 см орчим голчтой томоохон ваар байжээ. Одоо байгаа хагархай дээр гурван үе дусал хээ байна.

Булш-66. Оршуулгын газрын баруун урд үзүүрт буй 2 дахь булш юм. Бид тус булшийг 4 x 4 м талбайд хамруулан өнгөн хөрсний цэвэрлэгээг явуулав. 1-р үеийн цэвэрлэгээний дараа дараас бага зэрэг хөндөгдсөн нь ажиглагдаж байв. Дараасны чиглэл зүүн хойш чиглэлтэй зууван дугуй хэлбэртэй бөгөөд булшны хөл хэсгийн дараас нэлээд тарсан шинжтэй байв. Цэвэрлэх явцад дараас дундаас авсны мод бололтой модны үйрмэг, адуу, бодын тагалцгийн яс, хүний хурууны яс зэрэг илэрч байв. Дараасыг авахад зүүн хойш чиглэлтэй 2 x



Зураг 9. Були-62. Харандаа сувс.




Зураг 10. Були-62. 1. Царил, 2. Хутга, 3. Зэв, 4. Нумын гичрийн ясан эд, 5. Ваарын амсар, 6. Үйсэн эд, 7. Ваарын хагархай, 8. Алтан ээмэг, 9. Ногоон сувс, 10. Цахиур, 11. Цагаан чулуун зүүлт, 12. Мөнгөн сувс.


1.5 м оршуулгын нүх илрэв. Оршуулгын нүхний чигжээс чулуу нь мөн л хөл хэсэгтээ цөөн байв. Бид зүсэлтийг яг оршуулгын нүхний чиглэлд татсан байв. Малтлагын 1 м гүнээс ухмал модон авс бололтой урт өргөн тайрдас шиг цулгүй мод илрэв. Оршуулгын нүхийг том чулууг хавиргалан тойруулж тавиад түүний дунд авсанд талийгчаа хийж оршоожээ. Авсны гадна талаар хөвөөлсөн чулууны хооронд толгой талаар нь урт чулуу хөндлөн тавьж чигжсэн байна. Хөндлөн чулууг авахад авсны толгой талд ногоон паалантай вааран савны амсар цухуйв. Бид энэ түвшинд булшны хөл хүртэл жигд цэвэрлэв. Ногоон паалантай ваар дөрвөн талдаа босоо сэнжтэй бөгөөд 2 сэнжийг нь хугалан тавьсан байна. Ваар дарагдсанаас дундуураа хагарсан байна. Хүнээ хэвтүүлсэн нь бусад булшнаас арай өөрөөр зүүн хажуугаараа нь хандуулан хэвтүүлсэн байна. Ингэж хэвтүүлэх болсон нь нүүр тушаа зүүн талд нь нярайг бусад булшны адил баруун хажуугаар хэвтүүлсэн байна. Нярайг баруун гараараа дээр нь дарсан, тэврүүлсэн байртай тавьсан байсан болов уу. Ухмал модон авсыг үйсээр доторлосон эсвэл үйсэн эдлэл байж гэхээр багахан газарт үйс байв. Баруун гарыг тохойгоор нь нугалан түүний дээрээс далны яс хөмөрсөн байдалтай илрэв. Түүнийг эргүүлэн авахад хутга наалттай хэвээрээ байв. Энэ нь далны яс махтай маяа хэсэгт нь хутгыг шааж тавьдаг байсныг мөн баталгаа баримт юм. Учир нь энэхүү булшийг хөл талаас нь тоносон бөгөөд хүний яс байрандаа байгаа нь түүнд ямар нэгэн үнэтэй зүйлээр хучсан байсныг нь шувт татан авчээ хэмээн харагдаж байна. Үүнийг татах явцад баруун гар, дал мах татагдан анхны бус байрлалд очсон буюу дал хөмөрсөн бөгөөд хутга салалгүй далтай хамтаар

байгаа нь оршуулаад удаагүй байхад тонож гэж үзэхэд хүргэж байна. Талийгаачийн хүзүү орчмоос усны дусал мэт улаан сувс 1 ширхэг, (нугас) шувууны дүрс гарган сийлсэн сувс 1 ш, жижиг шар будаа шиг цагаан сувс 5 ширхэг илрэв. Нярайн яс болон хүний сарвууны яс зарим нь зөөгдсөн нь мэрэгч хэсэг үүрлэсний баримт бололтой. Ухмал модон авсны хөл хэсэг тодорхойгүй тонуулын явцад эвдэрсэн байна. Талийгаач нярайн хамт буйгаас харахад тухайн үеийн төрөлтийн хүндрэлийг илтгэх дурсгал хэмээн үзэж байна.

Олдворын тодорхойлолт. Усны шувуун сувс. Мана чулуугаар усны шувууг чадмаг сийлсэн бөгөөд нугас бололтой байна. Урт нь 2.4 см, өндөр нь 1.7 см байна. Нугас шувуу тайван хөвөөд явж буйг чадмаг сийлсэн байна. Шувууны цээжнээс сүвлэх нүх ухаад доош нөгөө талыг нь гаргасан байна. Сүвлэх нүхний голч 1.5 мм. Энэ нүхнээс харахад уг шувууг ямар нэгэн зүйл дээр хадах зориулалттай бололтой. Сүүл, амыг чадварлаг сийлсэн бөгөөд далавч, өдийг нарийн зураасаар чадмаг сийлжээ. Юаний үеийн үүнтэй төстэй хаш чулуун жинс байдаг. Сувс. Зүрх хэлбэртэй сувс дээд өргөн хэсэгт сүвлэх нүхийг гаргасан байна. Өндөр нь 1.6 см, өргөн нь 0.6 см, зузаан нь 0.5 см байна. Мөнгөн гархи. Ээмэгний гархи бололтой 1.8 см голчтой бөгөөд зузаан нь 0.2 см голчтой, уг гархинаас ямар нэгэн зүйл сувс уу, юм зүүж байсан утас ороолттой байна. Жижиг сувс. Шар будаа шиг жижиг сувс маш хэврэг 0.4-0.5 см голчтой. Сувс гадна талаараа алт шармал байсан байж магад жижиг шаргал зүйл салж унаж байна. Паалантай ваар. Өндөр нь 19.8 см, бөөрний хамгийн өргөн голч нь 15 см, амсрын нарийн үзүүрийн зузаан 0.3 см, Амсрын гадна тал 4 см голчтой бол дотор



Зураг 11. Були-66. 1. Паалантай ваар, 2. Нярайн яс. 3. Ээмэг, 5, 6 сувс. 7, 8. Богийн дал, хутга.



Зураг 12. Були-66. Дараас болон хөндлөн зүсэлт


тал нь 2.6 см голчтой байна. Хүзүүндээ дөрвөн сэнжтэй байсан бөгөөд хоёрыг нь хугалж, амсрыг нь бага зэрэг сэтлэн тавьжээ. Сэнжний зузаан 0.5 см, ёроол нь 7.7 см голчтой бөгөөд суурийн дотор талын голч 5.5 см байна. Суурийн хүрээний өндөр 1.2 см, зузаан нь 1 см. Ёроолоос нь барьж пааланд дүрсэн учир уг ваарын ёроол пааланд дүрэгдээгүй бөгөөд бөөрний зарим хэсэгт паалан урсан очсон боловч бүрэн бүрээгүй байна.

Тус оршуулгын газрын өмнө талаар тойруулсан шинжтэй зэл чулуу хориг уу? Эрээн толгойн байгалийн тогтоц болох зургаан талт харандаа чулуугаар зэл маягтай чулууг баруун хамараас зүүн хамар хүртэл, хоорондоо ойролцоо зайд том чулуудыг босгон татсан байна. Зэл болгон суулгаж байгаад одоо унасан шинжтэй гортиг баруун талаас эхлээд оршуулгын газрын урд талаар эмжин зүүн тийш явсан байдалтай байсан тул бид хамгийн томоохон хоёрыг сонгон малтаж үзэв. Ямар нэг тахил тайлгын зүйл илэрсэнгүй мөн газарт зоож, босгож байсан шинж илэрсэнгүй тэдгээр харандаа чулууг газарт өөрийн суурийг нь ашиглан жижиг чулуугаар ивэн босгож орхисон байж магадгүй юм гэсэн урьдчилсан дүгнэлтэд хүрлээ.

Судлаачид зарим дурсгалыг Хятаны үеийн Шивэй аймгийн түүхэн газар зүйтэй холбон тайлбарладаг. Тэгвэл бид эдгээр дурсгалуудын оршуулгын зан үйл, дагалдуулсан эд өлөг, хойлгын мал амьтнаар тэдний аж ахуйн талаарх сурвалжийн

маргаантай хэсгүүдийг тодруулж болох бөгөөд зарим нэгэн дурсгалыг мөн Шивэй-Татарын соёлд хамруулан авч үзэж болох юм.

Монгол нутагт Монголын үеийн хэмээх булшийг малтан судлаад өдгөө 100 гаруй жил болжээ. Одоогоор нийт 800 гаруй булш малтан судлаад буй боловч нарийн он цаггүй булшнуудыг хооронд нь ялгах боломж хомс байгаа бололтой. Бидний малтан судалсан Эрээн толгойн оршуулгын газрын зан үйл, зүг чиг, дагалдуулсан эд өлгийн байдлаар IX-X зууны Хятаны үеийн монголчуудын оршуулгын газар болох нь илэрхий байна. Гадна хэв шинж, дагалдуулсан эд өлөг, зан үйлээрээ Монголын үеийн булштай тун төстэй бөгөөд манай улсад хийгдсэн өмнөх малтлага судалгаанд үүнтэй төстэй дурсгал байгаа эсэхийг үзэх боломж үүсэж байна. Эрээн толгойн малтан судалсан арван булшны 4-р булш тэнэгэр байдлаар оршуулсан боловч толгойг нь зүүн хойд зүгт хандуулсан, 20, 66-р булш ухмал модон австай боловч тоногдсон, авсны байрлал нүхний чигээр харахад зүүн хойш чиглэсэн байна. 24, 35, 53, 4, 1, 3-р булшууд хүнээ баруун хажуугаар нь хэвтүүлээд хөлийг бага зэрэг атийлгасан байдалтай богийн дал, хутга заавал дагалдуулсан байна. 62-р булш хос оршуулгатай байсан бол 66-р булш насанд хүрсэн эмэгтэйг нярайн хамт, 56-р булш 5-6 насны эрэгтэй хүүхэд оршуулсан гэх зэргээр тус оршуулгын газрын бүхий л хувилбарыг малтан судалсан юм. Энэ төрлийн



Зураг 13. Булш-66. 1. Хар паалантай ваар. 2. Илэрсэн сүвс болон гархи сэргээсэн зураг. 3. Чулуугаар хийсэн шувуу. 4. Хутга.

булшны хөдөлшгүй нэгэн зан үйл нь бог, бодын дал дагалдуулах хутгыг хуудас маханд шаан тавьж дагалдуулах нь оршуулгын зан үйлийн хэв юм.

Энэ цаг үетэй ойролцоо булш оршуулгын дурсгал нь Байгал нуурын зүүн өмнөдөд малтан судалсан Бурхотуйн соёлын булш оршуулга тул нэлээд сонирхолтой байна. Энэ үеийн сурвалжид Өмнөд Шивэй, Умард Шивэй хоорондоо хэл соёл өөр хэмээн тэмдэглэсэн байдаг ба энэхүү хоёр соёлын ялгааг археологийн үүднээс холбон тайлбарлаж болох юм. Учир нь Бурхотуйн соёлын оршуулгын зан үйлд дагалдуулсан мал амьтан ховор бөгөөд ваар нь туузан аргаар үйлдсэн байдаг бол Эрээн толгой орчимын бүлгийн оршуулгаас богийн дал яс, эргэх хүрдний аргаар үйлдсэн дусал хээтэй Хятан ваар дагалдуулдаг онцлогтой. Үүнээс гадна зүг чигийн хувьд Бурхотуйн соёлын Новоселих хэлбэрийн булш буюу Голый-Мыс-ийн 20-р булшны А булш нь Эрээн толгойн булштай яг адил баруун хажуугаар нь хэвтүүлэн зүүн өмнө зүгт хандуулж нүүрэн талд нь богийн дал хутга дагалдуулсан булш байна. Тус булш нь сонгодог Бурхотуйн булштай нэгэн дараас доор Бурхотуйн булш нь (Б) хэмээн дугаарлагдсан байгаа нь тус хоёр соёл нэгэн цаг үед бус юм гэхэд бүс нутгийн хувьд их ойр байсныг илтгэх дурсгал юм (Kovychiev, 2012). ОХУ-ын судлаачдын үзсэнээр, Дарасуны оршуулгын газар нь 2-3 булшнаас бүрдсэн нь олон булш бүхий тусдаа оршуулгын газар биш Бурхотуйн оршуулгын газрын хаяа зах нийлэн оршдог. Үүний зэрэгцээ оршуулгын тал хувийг хүүхэд эмэгтэйчүүдийн булш эзэлдэг. Жижиг бүлэгт Бурхотуй, Дарасун хоёр соёлын дурсгалт газруудын онцлог шинж чанарыг хослуулсан холимог хэлбэрийн оршуулга багтдаг байна. Үүнээс харахад эдгээр соёлыг үлдээсэн овог аймгуудын хооронд ойр дотно ураг барилдах харилцаа холбоо байсныг илтгэж байж болно (Kovychiev, 2012) хэмээжээ. Бидний үзэж буйгаар хэдий Жужаны хаант улс мөхсөн ч ард иргэд нь аж ахуй, бэлчээрээ хаян ойн иргэд болох боломжгүй юм. ОХУ-ын судлаачид Байгалийн бүс нутагт буй Түрэг, Уйгурын он цагтай булшийг Гучин Татар, Есөн Татартай холбон тайлбарлаж буй нь хүлээн зөвшөөршгүй дүгнэлт юм. Ер нь ОХУ-ын судлаачдын энэхүү дүгнэлт нь ойн иргэд гарч ирж эзэнт гүрэн байгуулсан гэсэн далд санаа юм. Энэ бүс нутагт Бурхотуйн соёлыг үлдээгчид илүү ойн иргэдийн соёлтой, харин Хэнтий нурууны зүүн тал Дагуурын нурууны баруун талын буюу тус хоёр нурууны голын зүүнээс баруун 700 гаруй километр, хойноос урагш буюу Алс дорнодын Голый-Мыс оршуулгын газраас Сүхбаатар аймгийн нутгийн хойд хэсэг хүртэл багцаа нутгаар үзэхэд 800 километр өргөн уудам ойт хээр, тал хамарсан нутаг юм. Хөлөн-Буйр нуур ерөнхийдөө төвлөсөн шинжтэй. Есөн Татар, Түрэг, Уйгурын үед

өнөөгийн монголын зүүн аймаг болох Хэнтий, Сүхбаатар, Дорнодын талд улс төрийн зохион байгуулалтын хувьд өөртөө засах маягтай оршин тогтнож байсан юм. Энэ л бүс нутаг хожмын XII зууны үед өндийсөн Монголчуудын өвөг нутаг хэмээн заахаар байна.

Нийт малтан судалсан булшны 4 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй, 1 булш өсвөр насны хүүхдийн булш байсан бол 62-р булш хос хүний оршуулга, 66-р булш нярайн хамт оршуулсан эмэгтэй хүний булш байв. Нийт 11 бодгаль илэрсэн ба малтлагаас нийтдээ 60 орчим тооны олдвор илэрсэн юм.

Эрэгтэй хүний булшнаас зэр зэвсгийн шинжтэй зүйлс хоромсого, харвуулын зэв, нум зэрэг байв. Мөн 2 булшнаас хэт цахиур, хүйс хамаарахгүй зарим булшинд дангаар нь цахиур дагалдуулсан байв. Харвуулын зэвийн хувьд 24-р булшнаас илэрсэн ясан бороот зэв хамгийн онцгой зэв байсан бөгөөд бусад зэв нь дундад зууны үед түгээмэл хэрэглэгдэж байсан зэвүүд байв. Тус ясан бороот зэв нь Хүннүгийн үед түгээмэл хэрэглэж байсан боловч хожим тус зэвийг хэрэглэсээр байсан нь харагддаг (Kovychiev, 2006). Харвуулын зэв тийм томгүй ч цүүц хэлбэрийн, хийвэр гэх мэт хоёр жигүүрт зэв давамгайлж байна. Булш-24-өөс илэрсэн зэв гурван жигүүрт, нүдтэй ясан бороот сум, нэг ширхэг хийвэр зэв, булш-35-аас хоёр ширхэг цавчуур зэв илэрсэн байна. Булш-1-ээс илэрсэн зэвд том хийвэр зэв нэг, цавчуур зэв нэг ширхэг, гурван жигүүрт зэв нэг ширхэг, гилбэр хэлбэрт зэв нэг ширхэг, морьч хар зэв нэг ширхэг тус тус илэрсэн юм. Харин булш-62-оос хос оршуулга бөгөөд дагуул хүн нь эрэгтэй хүүхэд байсан учир нум нь жижиг, зэвүүд нь мөн жижиг байв. Гурван зэв нь морьч харын төрөл, нэг нь хийвэр зэв байсан бололтой хадгалалт муу байна.

Булш-24-ээс нумын бариулын ясан наалт илэрсэн. Булш тоногдсон байсан учир нумын бусад анги зөөгдөн гээгдсэн байхыг үгүйсгэхгүй юм. Булш-62-ын эзэн 55-60 насны эмэгтэй, дагалдуулсан хүн 12 орчим настай эрэгтэй хэмээн тогтоосон юм. Уг булшийг тонуулчид бусниулсан байсан учир бид эрэгтэй хүнтэй холбоотой эдлэл дагуул хүнд хамаатай байх магадлалтай хэмээн үзэв. Эндээс Нумын гичрийн ястай адил жижиг ясан эдлэл байна. Урт 4 см урт, 0.5 см урт, хамгийн өргөн 0.7 см нумын гичрийн модонд суух хэсэгт бага зэрэг нарийссан шаантаг маягтай юм. Үүнийг Ж.Базарсүрэн гуайн бүтээлд нумын “эвэр амагч” хэмээн нэрлэсэн байна (Bazarsuren, 2009). Гэвч яг нумд байрлаж буй хэсэгт хэр тохирч буй нь тодорхойгүй учир нум урлаач Т.Батмөнх гуайтай холбогдож ярилцахад “амгайвчийн онийн зуулга яс” гэж дээхэн үед суулгаж өгдөг байсан хэмээв. Булш ихээр тоногдсон учир нумын бусад бүрдэл яс илэрсэнгүй. Ер нь 12 орчим настай хүүхдийн нум

ясан амагчаас өөр ясан нэмэлт зүйлгүй байсан байж ч болох юм. Эрээн толгойн дурсгалтай ойролцоо он цагтай Хөлөнбуйрын Шар талын оршуулгын газрын 6-р булшнаас илэрсэн А хэлбэрийн нумаас харахад модон эх биетэй бариулын ясан наалт, ясан гичрээс өөр наалтгүй үйсээр ороосон байна. Гэвч 5, 7-р булшнаас нь илэрсэн В хэлбэрийн нум нь ясан эд ангигүй модон нумыг үйсээр ороосон энгийн нум байсан бололтой байна. Тэдний малтлагаас тус нумын хоёр гичрийн хэсэг хадгалагдаагүй илэрсэн бөгөөд гичрийн ясан наалт байсан бол муудсан хэсгээс ясан хийц нь илрэх байсан уу? гэдэг нь тодорхойгүй байна (Khailaer, 2006). Эрээн толгойн 62-р булшнаас илэрсэн ясан амагч нь нумын үзүүрийн гичрийн модны голд суулгаж өгсөн байжээ. Хүүхдийн нумын тухайд МНТ-ы §116-д “Тэмүжин, Жамуха хоёр Хорхонаг Жубурт нийлэн бууж эртний анд бололцсоноо дурдалцан, андаа сэргээж амраглая хэмээлдэв. Анх урьд анд бололцоход Тэмүжин арван нэгэн настай байхдаа Жамуха гурын шагай Тэмүжинд өгч, Тэмүжин нүхт шагай арилжиж анд бололцож, анд хэмээлдээд Ононы мөсөнд шагайлцахууд тэнд анд болцгоов. Түүний хойд хавар **алангир нумаар** харвалдан байхад Жамуха бярууны хоёр эвэр нааж нүхэлж хийсэн дуут сумаа Тэмүжинд өгч, Тэмүжиний арц [модон] толгойт годилтой арилжиж андлалдав. Ахин анд бололцсон ёсон тийм [ажээ]” (Tserensodnom, 2000).

Тус нумыг төсөөлөхөд алангир буюу хавчаахай нум бололтой байна. Нэрт археологич С.Мэнэс хавчаахайн тухай угсаатны мэдээ тэмдэглэсэн байдаг. Түүнийг бүрэн эхээр нь дурдвал “...Намайг бага байхад манай эндхийн Буриад зон хөвүүдээ хавчаахай хийж өгдөг байсан. Хавчаахайг хоёр хуруу бүдүүн зузаган гацуур модоор хийдэг ба нэг алд орчим урт байна. Хавчаахайг хийхдээ модны хальсыг хуулаад дүгрэг модныхоо голд бариул хийхээр хэсэг газар үлдээгээд тэрнээс хоёр тийшээ модны нэг талыг дүгрэгийн тал хүртэл нимгэлж авна. Хоёр үзүүрт углуур гаргана. Түүндээ хөвчөө бэхэлж нумаа хэрчсэн талаар дотогш матийлган нум болгоно” (Menes et al. 2008). Бидний илрүүлсэн ясан амагчаас харахад хоёр үзүүрт углуур гаргахгүй түүнд уг ясан амагчийг зуулга маягаар хавчуулан оруулж онь ухаж өгдөг байсан бололтой дүр харагдаж байна. Энэхүү ясан амагч нь биетээр илэрч буй бөгөөд алангир нумын эдэлгээг уртасгаж өгдөг байжээ. Шар талын алангир нумтай харьцуулан үзвэл тэдний нум гадна талаараа үйсээр мөн ороодог байсан байх. Эрээн толгойн хөрсний онцлогоос болоод үйс, мод маш муу хадгалалттай байгаа учир ингэж үзэж байна. Ийм нумыг Алангир нум хэмээн үзвэл зөвхөн хүүхэд хэрэглэдэг бус мөн насанд хүрэгчид бүгд хэрэглэдэг байсан бололтой. Магадгүй насанд хүрэгчдийн нумд шөрмөсөн

эд анги илүү ихээр ордог учир гадна талаар нь үйсээр ороодог байсан байж болох юм. Энэхүү нум нь ямар ч гэсэн төмөр зэв бүхий сумтай жижиг ан болон ахуйн хэрэгцээг хангадаг байж хэмээн үзэхээр байна. 62-р булшнаас дөрвөн ширхэг төмөр зэв илэрсэн нь ингэж үзэхэд хүргэж байна. Учир нь Шар талын булшнаас илэрсэн гурван нумын хоёр нь алангир нум байна. Булш 24, 62 хоёроос мөн хоромсого илэрсэн юм. 62-р булшны хүүхдийн хоромсогын хэсэг бололтой 10 x 10 см давхарлан бортого маягтай байж байгаад дарагдсан үйсэн эдлэл илэрсэн юм. Харин 24-р булшнаас илэрсэн хоромсого Эрээн толгойн он цагийг мөн давхар баталсан олдвор болсон бөгөөд зүүх сэнжийг ясаар хийсэн нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Арцат дэл, Өмнөговь аймгийн хийдэд хадгалагдаж байсан хоромсого зэрэгтэй ижилсэж байна. Мөн Өвөр Монголын Улаан хад хотын Ар Хорчин хошууны Зүүн Шавартай гацааны Эрдэнэ уулаас илэрсэн 1-р булшны ханын зурагт нум, сум, хоромсого дүрслэгджээ. Тус дүрсэлсэн хоромсого нь Хятаны язгууртны эдлэл гэдэг нь илэрхий мэдэгдэнэ (Sun Jian hua, 2009). ОХУ-ын Алтайн Мөнгөн-Тайгаас илэрсэн хоромсогын ясан чимэг нь бараг адил боловч зүүх гох нь модоор хийсэн (Savin et al. 1990) болохоос бусдаар адил байна. Мөнгөн Тайгаас илэрсэн хоромсогын ясан чимэглэл Эрээн толгойн 24-р булшнаас илэрсэн ясан чимэглэл бараг адил байх бөгөөд ясан бороотой зэвт сум нь хүртэл ижил байна. НТ VII-XI зууны үед нүүдэлчдийн хоромсого хийх арга барил Алтайгаас Хянган хүртэлх адил байсныг илтгэж байна. Энэ төрлийн хоромсогын ясан чимэгтэй нь зэрэг дэвийн илэрхийлэл байж болох бөгөөд Мөнгөн Тайга, Арцат Дэлийн хоромсого модон гогцоотой байгаа нь жирийн түгээмэл хийц модоороо байж гэдгийг илтгэж буй бололтой байна. Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Арцат дэлээс илэрсэн хоромсогоор сэргээн харвал хэд хэдэн үйсийг эвлүүлэн, гадна талаас нь туушид нь цуулсан савхаар чиг барин бэхэлж, хоромсогын амыг зорсон модоор хавчиж, үзүүрийг нь хажуугийн чиг модон доогуур шургуулан тогтоожээ. Зургаас үзвэл, амсар нь таглаатай байж болдог, харин түгжээ гэмээр зүйл байхгүй ажээ. Хоромсогын доод үзүүрт гонзгой модтой. Зүүн талд нь зүүж явахад зориулсан суран оосор оруулах хоёр модон сэнжтэй. Модон болон үйсэн хэсгийг хооронд нь нарийн суран үдээрээр үдэн бэхэлжээ (Erdenebat et al. 2005). Мөнгөн Тайгаас илэрсэн хоромсогын сэргээсэн зургаас харахад баруун талдаа зүүхээр сэргэсэн байх бөгөөд тухайн үеийн солгой хүн үү зарим ханын зурагт цөөн тохиолдолд зүүн талд зүүсэн тохиолдол байдаг. Тус хоромсого хавтгай модон дээр бэхлэгддэг байна. 24-р булшнаас илэрсэн хоромсогын яс чимгээс харахад тэдний

яс боловсруулалт бусад бүс нутгийнхантай ижил хэмжээнд хөгжсөн байсныг харуулж байна. Ясан дээр сийлсэн давхар онги мэт хээ Хятаны үед нэлээд түгээмэл байсан бололтой юм. Яг ийм хээтэй ясан эдлэл Чин толгой балгасны малтлагаас мөн илэрч байжээ (Ochir et al. 2008). Энэхүү давхар онгин хээтэй ясан эдлэл Алтайгаас Хянганы нуруу хүртэл түгсэн байгааг харахад Чин толгойн балгас мэт суурин газарт хийгдэж түгээгддэг байсан уу? гэх асуулт ургаж байна. Цаашид эд өлгийн судалгаагаар нарийн авч үзүүштэй сэдэв юм.

Хэт цахиурын хувьд хавтгай хуягийн ялтас мэт хэлбэртэй бөгөөд 0.5 см зузаан хавтгай хэлбэртэй төмөрт цахидаг байжээ. Үүнээс арай хожуу үеийн цахиур нь гарын атгын гадна талаар ороосон хагас цагариган болон өөрчлөгдсөн байдаг. Эрт үед цахиур чулууг гүр гэдэг байжээ. Чин толгой балгасны малтлага судалгаанаас ийм төрлийн хэт хэд хэд илэрсэн байдаг (Ochir et al. 2008). Тухайн үед хэтийг хуягийн ялтасны бэлдэц хэмээн багахан ташаарсан байна. Булш-62 тонуулчдын нүхнээс нэгэн төмөр эдлэл илэрсэн юм. Тус эдлэл нь жадны гилбэр мэт боловч үзүүр мохоо, хөндлөн огтлол тэгш өнцөгт юм. Үзүүр тал руугаа хурц байсан байж болох боловч энэ үеийн жадны гилбэрт тун цөөн тохиож байна. Эгийн голын Мухдагийн амны 8-р булшнаас яг адил багаж илэрсэн байна. Тухай эдлэлийг жадны төмөр хошуу хэмээн тодорхойлсон байна (Turbat et al. 2003). Уг булшинд анхнаасаа тавьсан жад уу эсвэл тонуулчдын булшийг тонохдоо ашигласан багаж байж болохоор мөн л тоногдсон булш ажээ.

Бараг бүх булшинд далны маханд хутга шааж дагалдуулсан байна. Хутга бүгд зуулга бүхий модон иштэй байсан бөгөөд зуулгын хамт хамгийн урт нь 1-р булшны хутга байв. Нийт урт нь 25 см бөгөөд ир нь 13 см, ишний зуулга 12 см орчим байв. 3-р булшны хутга 11 см урт байсан. Зуулган дээр модон ишний үлдэгдлээс харахад зуулга нь 3 см орчим сууж байсан нь харагдана.

Нийт малтан судалсан 9 булшнаас 6 ваар илэрснээс бүтэн ваар 4 ш, хагархай ваар 2 ширхэг байна. Бүтэн вааруудыг булшны толгой орчимд байрлуулсан нь тэдний тогтсон зан үйл байна. Ваар гурван төрөл байгаа бөгөөд Хятан улсын үеийн шатаалт сайтай саарал дусал хээт ваар голлож байна. 66-р булшнаас Хятан, Алтан улсын үед хэрэглэгдэж байсан пааландсан ваар илэрсэн юм.

Эрээн толгойн булшнаас гоёл чимэглэлийн зүйлс харьцангуй ихээр илэрсэн бөгөөд энэ үеийн эмэгтэйчүүд үнэт эдлэл ихээр хэрэглэж байсны илрэл гэлтэй. Дийлэнх нь тоногдсон ч үлдэн хоцорсон нь энэхүү чимэглэлийг авах зорилгоор бус тэдний өмссөн юм уу нөмөргөсөн зүйлс илүү үнэтэй зүйл байсан уу гэх таамгийг төрүүлж байна. 66-р булш хөл хэсгээс нь орж нөмөргөсөн зүйлийг















авсан бололтой хүний яс анхны байдлаараа хэр нь дал, хутга доош татагдан хөмөрсөн байдалтай илрэв. Мөн 3-р булшны хүнээс бүсэлхий орчмоос нь ямар нэг зүйл татаж авсан шинжтэй бөгөөд бид эрэгтэй хүний бүсийг татаж авсан хэмээн бодсон боловч хүний ясны хэмжилтээр эмэгтэй хүн болох нь тогтоогдсон юм. 20, 62-р булш бараг бүрэн тонуулд өртсөн бөгөөд тэдний алтан ээмэг, сувс зэрэг зүйлс нь үлдэн хоцорсон байгаагаас харахад тэднээс илүүтэй үнэт зүйлс байж хэмээн үзэхэд хүргэж байна.

Эрээн толгойн оршуулгын газраас илэрсэн сувснуудын дийлэнх нь маньн төрлийн чулуугаар хийгдсэн байна. Булш-62 илэрсэн ногоон сувсыг ногоолин чулуугаар хийсэн бололтой чулууны хээ, судал ширхэг харагдах бөгөөд аажмаар өнгө нь хувирч цайвар ногоон болж байна. Булш 62, 3 хоёроос харандаа хэлбэртэй нарийн урт мана чулуугаар хийсэн сувс гарсан нь нэлээд онцлогтой сувс байв. Булш 62 - оос илэрсэн харандаа сувстай хамтаар мөнгөлсөн зүрх хэлбэртэй цагаан болор чулуун сондор, мөнгөн жааз бүхий хар сувс илэрсэн юм. Энэхүү чимэглэл нь Хятаны язгууртны бунхнаас түгээмэл илэрдэг бөгөөд зүрх хэлбэрт сувсны хамтаар “Т” хэлбэрийн сувс үргэлж хамт илэрдэг ажээ. Гэвч 62-р булшнаас энэхүү “Т” хэлбэрийн сувс илрээгүй юм. Магадгүй тонуулчдын нөлөөллөөр гээгдсэн байхыг үгүйсгэхгүй. Зүрхэн хэлбэрт болор унжлага зүүлтийн мөнгөн дээр нь ямар нэгэн навчин хээ юм уу бадма цэцгийг сийлсэн байж болохоор харагдаж байна.

66-р булшнаас хув чулуугаар сийлсэн усны шувууны дүр бүхий эдлэл илэрсэн. Гэвч бид тус эдлэл нь Хятаны үеийн ээмэг байж болох юм хэмээн үзсэн боловч унжлага гэхээсээ илүүтэй ямар нэгэн зүйл дээр хадах зориулалттай сүвлэх нүх нь доошоо чиглэлтэй байгаа юм. Бид хамт илэрсэн жижиг будаан сувс, мөнгөн гархи, усны дусал хэлбэртэй хув сувс зэргийг хамтад нь сэргээн ээмэг болгож үзсэн. Гэвч шувуу хэлбэртэй сувсны сүвлэх нүх тохирохгүй байгаа учир гоо зүйн хувьд зохимжгүй сэргээлт болж байна. Уг булшинд нярайн хамт эмэгтэй хүн оршуулсан байсан бөгөөд энэхүү эдлэл нярайд зориулан дагалдуулсан малгайн жинс байж болох юм. Үүнтэй төстэй Юаний үеийн малгайн хаш жинс БНХАУ-ын хувь цуглуулагч хүнд хадгалагдаж байна.

Эрээн толгойн 20, 62, 4-р булшнаас “G” хэлбэрийн тээгт ээмэг илэрсэн юм. Булш-20-ийн ээмэг бол харьцангуй хожуу загвар хэмээн үзэж байна. Булш 62, 4-р булшнаас илэрсэн ээмэг бол сонгодог “G” хэлбэрийн тээгт ээмэгний хувьссан хэлбэр юм. Энэхүү ээмэг нь анх Жужан, Түрэгийн хаант улсын үед эрэгтэй хүний тээгт ээмэг байж байгаад аажмаар эмэгтэй хүний гоёлд шилжсэн ээмэг юм.

Хүснэгт 1.

	Булш-24	Булш-56	Булш-4	Булш-66
Эрээн толгой оршуулгын газар				
	Булш-4	Булш-6	Булш-8	Эрээн толгой Булш-66
БНХАУ-ын Хөлөнбуйрын Шар талын оршуулгын газар				
	Ляо голын оршуулгын газрын 4-р булш	Баруун Үзүүрийн оршуулгын газар	Шинэ Барга хошууны Ганжир Хуа булш-3	Хар мөрөн мужийн А чен туурь, Алтан улсын үе
БНХАУ-ын Зүүн ход бүсийн Хятан, Алтан улсын үеийн хот суурин, булшнаас илэрсэн.				
	Эгийн гол, Мухдагийн ам-7	Чинтолгойн балгас	Эрээн толгойн Булш-62	Чинтолгойн балгас
Бүс нутгийн Хятаны үеийн дурсгалд буй ваар				

Эрээн толгойн ваарууд Хятаны түрүү үеийн ваарууд бөгөөд ойролцоо цаг үеийн оршуулгын газраас илэрсэн ваартай ижил байна. Хүснэгт 1.


Бидний үзэж буйгаар, хүүхдийн булш зарим том булшнаас газрын дээр үйлдсэн болон том хэмжээний булш дийлэнх нь газрын доод талаар байрлаж буй зэргээс харахад энэхүү оршуулгын газрын том булшнуудыг хамгийн анх үйлдсэн хэмээн үзэхээр байна. Жижиг булшнууд болон хүүхдийн булш нь арай хожуу үйлдсэн хэмээн үзэж байна. Учир нь том хэмжээтэй булш чинээлэг, настай, язгуурлаг нэгний булш бололтой бөгөөд хэсэг хугацааны дараа тэд мартагдан хожуу үйлдсэн булш илүү газрын дээр хүнээ оршоох гэж эрмэлзсэн шинжтэй харагдаж байна. Эрээн толгойн дурсгалаас түүврээр болон малтлагаас неолитын үеийн чулуун зэвсэг мэр сэр илэрч олдож буй нь энэ орчимд неолитын үеэс амьдрал өрнөж байсныг илтгэж байна. Энэхүү дурсгал нь VII-XI зууны Хятаны үеийн Зүбү (Шивэй) аймгуудын түүх,

түүхэн газар зүйн судалгаа хийхэд чухал дурсгал болж байна.


Эрээн толгойн оршуулгын газраас илэрсэн вааран сав, ээмэг, оршуулгын зан үйл зэргээс харахад БНХАУ-ын Хөлөнбуйрын нутаг Шар талын булш, ОХУ-ын Бурхотуйн соёлын Амаголон хэлбэр зэрэгтэй оршуулгын зан үйл, дагалдуулсан эд өлгийн зүйлсээр ижилсэх бөгөөд нэг цаг үеийн дурсгал байна. Өөрөөр хэлбэл урьдчилсан байдлаар өвөг монголчуудын буюу VII-XI зууны үеийн дурсгал болж байна. Тиймээс цаашид Монголын ойт болон хээрийн бүсийг заагласан зүүн хойд талын Чингисийн далангаас урагш, хойш буй оршуулгын газрыг харьцуулан судалбал сонирхолтой түүхэн гаргалгаа хийж болох юм. Бид 2021 малтан судалсан 4 булш дээр C¹⁴-ийн он цаг тогтоох шинжилгээ хийж үзэхэд X-XI зуун хэмээх үр дүн гарсан бөгөөд Монголын эзэнт гүрний өмнөх үеийн булш оршуулгын дурсгал болох нь тогтоогдсон.




Зураг 14. Хятаны бунхны ханын зурагт дүрсэлсэн нум, хоромсого.



Зураг 15. Булш-24 илэрсэн хоромсого сэргээсэн зураг.



Зураг 16. Эрээн толгойн дурсгалын дэвсгэр зураг ба 2021, 2024 онд малтан судалсан булс






Зураг 17. Эрээн толгойн булинаас илэрсэн сувс.



Зураг 18. Були-53. Ваар



Зураг 19. Були-56. Ориуулгын байдал



2021 онд Эрэн толгойд малтан судалсан булшны он цаг

НОМ ЗҮЙ

Ковычев Е В. К вопросу о древних связях племён Восточного Забайкалья с тюркоязычными соседями в I тыс. н.э. // Археология Северной Азии. Новосибирск: 1982. С. 148-156

Ковычев Е В. Некоторые вопросы этническое и культурной истории Восточного Забайкалья в конце в тыс. До н.э в тыс. Н. Э. Эпока палеометолла. Чита., 2006, 247-249

Базарсүрэн Ж. Чингис хааны цэргийн зэр зэвсэг. УБ., 2009, 192.

Батболд Г, Цогтбаатар Б, Лхүндэв Г, Жамьян Г. Эрэн толгойн дурсгалын малтан шинжилсэн үр дүнгээс. Монголын археологи-2021. УБ., 2021, 209-218.

Батболд Г. Хэнтий аймгийн Дадал сумын Эрэн толгойд явуулсан малтлага судалгааны тайлан. УБ., 2024. ШУА-ийн Археологийн хүрээлэн сан хөмрөг.

Ковычев Е В. К истории ранних монголов в Забайкалье // Известия лаборатории древних технологий. Вып 9. Иркутск, 2012. с. 129-146,

Мэнэс Г, Номгонсүрэн Г. “Монголын нууц товчоон” хийгээд бусад сурвалж бичиг дэх мэдээгээр нум сум болон зэвийн дүрс хэлбэрүүдийг тодруулах нь. Археологийн судлал. Том (VI) XXVI. Fasc. 19. УБ., 2008.

Окладников А.П. Бурхотуйская культура железного века в юго-западном Забайкалье // История и культура Бурятии: Сб. ст.-Улан-Удэ, 1976. 361-377

Очир А, Крадин Н Н, Ивильев А Л, Данилов С В, Эрдэнэболд Л, Никитин Ю Г, Энхтөр А, Анхбаяр Б, Батболд, Г. Чинтолгой балгасны судалгаа. УБ., 2008, 138

Савин А Н, Семёнов И А. Колчан Древнетюркского времени из Монгун-Тайга 9MT-1958-X-2 0 Худяков Ю С, Плотников, Ю И. Хойд ба Төв Азийн эртний болон дундад зууны үеийн хүн амын цэргийн түүх. Новосибирск., 1990, 81-96

Төрбат Ц, Амартүвшин Ч, Эрдэнэбат, У. Эгийн голын археологийн судалгаа. УБ., 2003. 109-110

Цэрэнсодном Д. Монголын нууц товчоо. УБ., 64

Эрдэнэбат У, Эрнст П. Монгол орны хадны ангал, агуйн булш. Чингис хаан ба түүний залгамжлагчид. УБ., 2005, 57-59.

Khailaer Xieer Tala Mu di. Zhongguo Kexue yuan Kaogu yanjiu suo, Khulun Beier Minzu Bowuguan, Khailaer qu Wenwuguanli suobian zhe. Beijing: kexueyuan chuban she. 2006.43-45

Sun Jian hua. Nei Menggu Liao dai bihua. Wenwu chuban she. Beijing. 2009. 38-39

REFERENCES

Batbold, Gonchig. Khentii aimgyn Dadal sumyn Ereen tolgoi yavuulsan maltaga sudalgaany tailan. UB. 2024. SHUA- Arkhyeologiin khureelen san humrug.

Batbold. Gonchig. Tsogtbaatar Batmunkh, Guunii Lkhundev, Ganbold Jamiyan. Ereen tolgoi dursгалыг maltan shinjilsen ur dungees. Mongolyn arkheologi-2021. UB. 2021. 209-218

Bazarsuren, Jamba. Chingis khaany tsergiin zer zevseg. UB. 2009. 192

Erdenebat, Ulambayar, Ernist. Puul. Mongol орны хадны ангал, агуйн булш. Чингис хаан ба тууний залгамжлагчид. UB. 2005. 57-59

Khailaer Xieer Tala Mu di. Zhongguo Kexue yuan Kaogu yanjiu suo, Khulun Beier Minzu Bowuguan, Khailaer qu Wenwuguanli suobian zhe. Beijing: kexueyuan chuban she. 2006.43-45

Kovyichev, Evgenii B. K istorii rannyikh mongolov b Zbaikalie// Izvestiya laboratorii drevnikh tekhnologii. Vyip 9. Irkutsk, 2012. s. 129-146

Kovyichev, Evgenii B. K voprosu o drevnikh svyzyakh plemyon Vostochnogo Zabaikaliya c tyurkoyazyichnyimi sosedyami v I tyis. n. e. // Arkheologiya Severnoi Azii. Novosibirsk: 1982. s. 148-156

Kovyichev, Evgenii B. Nekotoryie voprosy etnicheskoi i kulturnoi istorii vostochnogo zabaikaliya v konce I tyis. Do.n. e- I tyis. n. e. Epokha paleometalla. Chita. 2006. 247-249

Menes, Gochoo, Gonchigsuren Nomguunsuren. "Mongolyin nuuts tovchoon" khiigeed busad survalj bichig deh medeegeer num, sum bolon zeviin durs khelberuudiig todruulakh ni. Arkhyeologiin sudlal. Tom (VI) XXVI. Fasc. 19. UB., 2008.

Ochir, Ayudai, Kradin Nikolai N, Ivliev Aleksandr L, Danilov Sergei V, Lkhagvasuren Erdenebold, Nikitin Yurgii G, Altangerel Enkhtur, Batsuuri Ankhbayar, Gonchig Batbold. Chintolgoi balgasny sudalгаа. UB. 2008. 138

Okladnikov, Alexey P. Burkhotuiskay kulitura jeleznogo beka b yugo-zapadnom Zabaikalie// Istoriya n kulitura Buryatii: SB. Ulan-Ude, 1976

Savin, Aleksandr N. Semenov, Ivan A. Kolchan Drevneturkskogo vremeni iz Mongun-Taiga (MT-1958-X-2) Khudyakov, Yulii S. Plotnikov, Yurii I. Voennoe delo Drevnego I Srednevekovogo naseleniya Severnoi I Centralnoi Azii. Novosibirsk. 1990. 81-96

Sun Jian hua. Nei Menggu Liao dai bihua. Wenwu chuban she. Beijing. 2009. 38-39

Tserensodnom Dalantai. Mongolyin nuuts tovchoo. Ulaanbaatar. 2000. 64

Turbat, Tsagaan, Chunag Amartuvshin, Ulambayar Erdenebat. Egiin golyin arkheologiin sudalгаа. UB. 2003. 109-110



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>